

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР
ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2017 он)**

НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

| | | |
|--|--|---|
| <p><i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийг шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i></p> | <p><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p> | <p><i>Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p> |
| <p>Нэг. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ</p> | | |
| <p>1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх;</p> | | |
| <p>1.1.1. Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. 1.1.2. Статистикийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллана.</p> | <p>1.1.1. Статистикийн тухай хууль, Хүн ам орон сууцны тооллогын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг ханган ажиллаж байна. 1.1.2. Статистикийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.</p> | |
| <p>1.2. “Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх;</p> | | |

| | | |
|---|---|--|
| <p>1.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ажиллана.</p> <p>1.2.2. Хэрэгжилтийг ҮСХ-нд тайлагнана.</p> | <p>“Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд статистикийн салбарын нэгдсэн сүлжээг байгуулж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн ашиглаж байна.</p> | |
| <p>1.3. Тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах;</p> | | |
| <p>1.3.1. Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол болон эрх бүхий этгээдээс гаргасан бусад эрх зүйн актын биелэлтийг хангаж ажиллана.</p> <p>1.3.2. Хорооны дарга, Тамгын газрын даргын тушаал, чиглэл, үүрэг даалгавар болон холбогдох газраас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллана.</p> | <p>1.3.1. Статистикийн салбарын үйл ажиллагаатай холбоотой Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол болон эрх бүхий этгээдээс гаргасан бусад эрх зүйн актын биелэлтийг хангуулж ажиллалаа.</p> <p>1.3.2. Үндэсний статистикийн хорооны дарга, Тамгын газрын даргын тушаал, чиглэл, үүрэг даалгавар болон холбогдох газраас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулан ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> | |
| <p>1.4. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах;</p> | | |
| <p>1.4.1. Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн болон биет хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, өмч хөрөнгийн тооллого явуулна.</p> <p>1.4.2. 2017 оны төсвийн төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог хангаж ажиллана.</p> <p>1.4.3. Жилийн эцсийн 2017 оны санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд гаргана.</p> <p>1.4.4. 2018 оны төсвийн төслийг боловсруулж, ҮСХ-нд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.</p> <p>1.4.5. Төсөв, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой ажил санаачлан зохион байгуулна.</p> | <p>1.4.1. Үндсэн дансны жилийн батлагдсан төсөв нь 72463,4 мянган төгрөг. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 60238.1 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 6192.7, Бараа үйлчилгээний зардалд 5381.4 мянган төгрөг, Тээврийн хэрэгслийн зардалд 355.5 мянган төгрөгийг зарцуулаад байна. Өмч хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр явуулан ажилтан нэг бүрийн эд хөрөнгийн картыг шинэчлэж өглөө.</p> <p>1.4.2. 2017 оны төсвийн төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог ханган ажиллаж 2017 оны төсвийн гүйцэтгэлээр өр төлбөргүй гарлаа.</p> <p>1.4.3. Жилийн эцсийн 2017 оны санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд нь гаргахад бэлэн болоод байна.</p> <p>1.4.4. 2018 оны төсвийн төслийг боловсруулан гаргаж ҮСХ-ны санхүүгийн хэлтэст заасан хагацаанд нь гаргаж хүргүүллээ.</p> <p>1.4.5. Төсөв зардлыг бууруулах чиглэлээр</p> | |

| | | |
|---|--|--|
| 1.5. ҮСХ-ны даргын 2016 оны А/79 тоот тушаалаар баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар цуглуулж, дамжуулах; | | |
| <p>1.5.1. Улсын хэмжээний 8 тооллого, судалгаа болон албан ёсны статистикийн 46 төрлийн мэдээ, тайланг маягтын дагуу мэдээллийг цуглуулж, дамжуулна.</p> <p>1.5.2. Мэдээний маягт, заавар, аргачлалыг сум, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, мэдээ цуглуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>1.5.3. Ажилтан бүр цуглуулсан мэдээллийг маягт бүрээр нэг бүрчлэн шалгаж, алдааг засаж, протокол хөтөлнө.</p> <p>1.5.4. Мэдээллийг салбар бүрээр, программаар нэгтгэн боловсруулна.</p> <p>1.5.5. Мэдээллийг электрон хэлбэрээр графикт хугацаанд нь Ерөнхий газарт дамжуулна.</p> <p>1.5.6. Маягт бүрээр мэдээ тайланг цуглуулсан, дамжуулсан талаарх бүртгэлийг хөтөлсөн байна.</p> | <p>1.5.1. Үндэсний Статистикийн Хорооны даргын мэдээ тайлангийн график батлах тухай 2016 оны 12-р сарын 28-ны өдрийн А/79 тоот тушаалаар баталсан албан ёсны статистикийн 54 мэдээ тайлан гаргахаас аймгийн хэмжээнд гаргах 46 мэдээ тайлан, захиргааны 18 төрлийн мэдээ тайлан, 7 судалгааг 9388 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 10825 удаа авч шалгаж боловсруулан 275 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 275 удаа графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа.</p> <p>1.5.2. Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны “Албан ёсны статистик мэдээний график”-ийг шинэчлэн баталсан А/79 дүгээр тушаалыг үндэслэн аймгийн хэмжээнд мэдээлэх “Статистик мэдээний график”-ийг хэлтсийн дарга батлан сумд болон мэдээлэгч нарт хүргэж, хэрэгжилтийг ханган сум, ААНБ-аас мэдээ тайланг цуглуулан боловсруулж дамжууллаа.</p> <p>1.5.3. Мэдээний маягт, заавар, аргачлалыг 18 сум,4 тосгон, 600 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад онлайн болон цаасаар хүргүүлэн, мэдээ цуглуулах ажлыг зохион байгуулан Оны эхэнд сумдад албан ёсны статистикийн мэдээ тайлангийн графикийг шинэчлэн хүргүүлж, графикийн биелэлт, мэдээний ирцийг сар бүр бүртгэж ажиллалаа.</p> <p>1.5.4. Мэргэжилтэн бүр хариуцсан салбарын мэдээг цуглуулан нэгтгэн боловсруулж мэдээллийг сар, улирал, жилийн эцсийн программуудад оруулан шивж ҮСХ-д графикт хугацаанд нь хоцрогдолгүй дамжуулж ирлээ.</p> <p>1.5.5. 9388 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 10825 удаа авч шалгаж боловсруулан 275 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 275 удаа графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа.</p> <p>1.5.6. Мэргэжилтэн бүр өөр өөрсдийн хариуцсан салбарын мэдээ тайланг цуглуулан дамжуулсан талаар бүртгэл хөтөлж мэдээллийн сан үүсгэн хадгалж, ахлах мэргэжилтэн мэдээда мжуулалтын ирц бүртгэн ажиллаж байна. Энэний үр дүнд мэдээний хоцрогдолгүй ажиллалаа.</p> | |
| 1.6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус хэлтсийнн чиг үүрэгт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх; | | |
| <p>1.6.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус хэлтсийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.</p> <p>1.6.2. Тухайн хөтөлбөрийн биелэлтийг аймгийн Засаг даргад тайлагнана.</p> | <p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжин ажиллаж аймгийн Засаг дарга , ИТХ-н дарга, орон нутгийн удирдлагууд болон байгууллагуудын дарга мэргэжилтнүүдийг шаардлагатай тоон мэдээллээр хангаж ажиллалаа.</p> | |
| 1.7. Аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын хэрэгцээнд шаардлагатай захиргааны статистикийн | | |

| | | |
|---|---|--|
| мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийх; | | |
| <p>1.7.1. Мэдээллийг 40 маягтын дагуу мэдээлэгчдээс цуглуулна.</p> <p>1.7.2. Мэдээллийг боловсруулан хянаж, нэгтгэн эмхэтгэл, танилцуулгаар тархаана.</p> | <p>1.7.1. Сарын танилцуулгын мэдээллийг 40 маягтын дагуу мэдээлэгч байгууллагуудаас авч цуглуулан боловсруулна. Үүнд: Аймгийн үндсэн үзүүлэлтүүд, Нийгмийн зарим үзүүлэлтүүд, Аж үйлдвэр, Өрх, хүн ам нийгмийн зарим үзүүлэлт, Нийгмийн халамж, Нийгмийн даатгал, Ажилгүйдэл, Гэмт хэрэг, Шүүх, онцгой байдлын үзүүлэлт, Боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдийг сүүлийн 2-3 жилээр зэрэгцүүлэн гаргасан.</p> <p>1.7.2. Статистикийн сар бүрийн бюллетень, танилцуулгын агуулгыг баяжуулан өргөжүүлж аймаг орон нутгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудад биет хэлбэрээр 248 ширхэг тархааж мэдээллээр хангаснаас гадна статистикийн хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг цахим хэлбэрээр 300 гаруй хүнд тархаасан байна.</p> | |
| 1.8. Хөдөө аж ахуйн 2017 оны завсрын тооллогыг зохион байгуулах | | |
| <p>1.8.1. Баталсан үзэл баримтлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу мэдээллийн үнэн бодит байдлыг ханган цуглуулж, боловсруулна.</p> <p>1.8.2. Мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор бие даасан болон бусад байгууллагатай хамтарсан хяналт, шалтгалтыг хийнэ.</p> <p>1.8.3. Хяналт шалгалт, мониторингоор илрүүлсэн зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулна.</p> | <p>1.8.1. Хөдөө аж ахуйн завсрын тооллогыг 2017 оны 11 сарын 06-аас 12 сарын 10-ны хооронд Хэнтий аймгийн 18 сумын 88 багийн 5338 өрх, 53 аж ахуйн нэгжийг хамруулан баталсан үзэл баримтлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгууллаа. Тооллогод хамрагдсан өрх, ААН-үүд бүгд батлагдсан маягт, зааврын дагуу мэдээлэлээ өгөв.</p> <p>1.8.2. Мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор сумдаас ирж байгаа маягтыг хянан шалгаж хүлээн авлаа..</p> <p>1.8.3. Тооллогын маягт хянах явцад гарсан асуудлыг тодруулан засаж онлайн программд шивж оруулан хугацаанд нь ҮСХ-д дамжууллаа.</p> | |
| 1.9. Хөрөнгө оруулалтын судалгааг зохион байгуулах; | | |
| <p>1.9.1. Улирлын судалгааны мэдээллийг ҮСХ-ноос баталсан үзэл, баримтлал, маягт, зааврын дагуу ААНБ-аас үнэн зөв, бодитой гаргуулан авна.</p> <p>1.9.2. Судалгааны үр дүн, мэдээг хугацаанд нь ҮСХ-нд дамжуулна.</p> | <p>1.9.1. ҮСХ-ноос баталсан үзэл баримтлал, маягт зааврын дагуу доорхи ААН-дээс судалгааг гаргуулан авлаа.. Үүнд:</p> <p>Хурх тосгоны “Хурх гол” ХХК Бэрх тосгоны “Бэрх Уул” ХХК Бор-Өндөр сумын “Бор-өндөр хөгжил” ОНӨҮГ Биндэр сумын “Биндэръяа буудай” ХХК Хэрлэн сумын “ Хэнтий Ус” ХХК, “Харгуй” ТӨҮГ,” гэсэн аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдсан байна.</p> <p>1.9.2. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан болон анхан шатны бүртгэлийн мэдээлэлд үндэслэн аж ахуйн нэгжийн нягтлантай хамтран ажиллаж судалгаагаа авч нэгтгэн программд оруулан шивж ҮСХ-д хагацаанд нь дамжуулсан болно.</p> | |
| 1.10. Үйлдвэрлэгчийн үнийн мэдээг /аж үйлдвэр, барилга, тээвэр, зочид буудал, зоогийн газар, холбоо/ цуглуулах; | | |

| | | |
|--|--|--|
| <p>1.10.1. ҮСХ-ноос баталсан удирдамж, зааврын дагуу мэдээллийг цуглуулна.</p> <p>1.10.2. Үр дүн, мэдээг нэгтгэн боловсруулж, ҮСХ-нд дамжуулна.</p> | <p>1.10.1. Үйлдвэрлэгчийн үнийн мэдээг ҮСХ-ноос баталсан удирдамж зааврын дагуу АҮ- 2 ААН, Зочид буудал,зоогийн газрын 8 ААН, Барилгын 5 ААН нийт 15 аж ахуйн нэгжээс мэдээллийг цуглуулж байна.</p> <p>1.10.2. Үйлдвэрлэгчийн үнийг мэдээнд 15 ААН хамрагдаж тэднээс авсан мэдээллийг нэгтгэн боловсруулж программд шивэн хугацаанд нь ҮСХ-д дамжууллаа.</p> | |
| <p>1.11. “Эрчим хүчний үйлдвэрлэл хэрэглээ-2015, 2016” судалгаа:</p> | | |
| <p>1.11.1. ҮСХ-ноос баталсан үзэл, баримтлал, маягт, зааврын дагуу мэдээллийг цуглуулна.</p> <p>1.11.2. Судалгааны үр дүн, мэдээг нэгтгэх, боловсруулан ҮСХ-нд дамжуулна.</p> | <p>1.11.1 “Эрчим хүчний үйлдвэрлэл хэрэглээ-2015,2016” судалгааг Хэнтий аймагт 2017 оны 5-р сарын 25-наас 6-р сарын 20-ны хооронд явууллаа. Судалгаанд сонгогдсон 34 ААН-с аймгийн төвд 2 том, 10 бусад ААН, сумдад судалгааг биечлэн авсан 1 том, 12 бусад ААН, сумдаас утсаар судалгааг авсан 9 бусад ААН-д тус тус сонгогдсон байна. Сумдаас авах ААН-с Биндэр сумын Баянбүрдийн өгөөж ХХК нь хасагдсан болно.Судалгаанд тоологчоор А.Наранчимэг, Э.Ариунтунгалаг, М.Одгэрэл нар ажиллаа. Судалгаанд хамрагдах ёстой 34 ААН-ээс 1 ААН хасагдаж 31 ААН бүрэн хамрагдаж 2 ААН тайлбар өгөв. Боорчийн зам ХХК-р зардал гараагүй зөвхөн зуучлагчийн үүрэг гүйцэтгэсэн талаар тайлбар бичүүлж тамга даруулан гарын үсэг зуруулсан, Баянмөнх тохижилт ХХК нь 2015, 2016 онд санхүүжилтгүйн улмаас үйл ажиллагаагаа явуулаагүй, захирал нь тамгаа олохгүй байсны улмаас тайлбар бичиж өгөөгүй сумын төрийн сангийн мэргэжилтнээр тайлбар бичүүлэн тамга даруулж гарын үсэг зуруулж авлаа.</p> <p>1.11.2. Судалгаанд хамрагдсан ААН-дийн судалгааны асуулгын маягтыг нэг бүрчлэн шалгаж ҮСХ-ны мэргэжилтэн Мягмархатанд шалгуулан өөрийн биеэр хүлээлгэн өглөө.</p> | |
| <p>1.12. Мал тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулах;</p> | | |
| <p>1.12.1. Малын хагас, бүтэн жилийн тооллогыг явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.</p> <p>1.12.2. Мал тооллогыг сумдад зохион байгуулах ажилтнуудын сургалт, семинар /аргачлал болон программ зэрэг/-ыг явуулах.</p> <p>1.12.3. Малын тооллогыг оновчтой зохион багуулах мэргэжлийн удирдлагаар хангана.</p> <p>1.12.4. Мал тооллогын дүн мэдээг өр бүрээр онлайнаар шивэх бэлтгэл</p> | <p>1.12.1. Эхний хагас жилийн мал тооллого, түүвэр судалгааг 2017 оны 6 сарын 15 наас эхлэн хуулийн дагуу 7 хоног орон даяар зохион байгууллаа. Тооллого түүвэр судалгаанд Хэнтий аймгийн бүх сумдыг хамруулан нийт малчин өрхийг төлөөлөх чадвар бүхий 1532 өрхүүдийг түүвэрлэн тооллого явуулав.</p> <p>Аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/431 тоот захирамжаар жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг 13 гишүүнтэй томиллоо. Аймгийн комиссын даргаар аймгийн засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун, орлогч даргаар Статистикийн хэлтсийн дарга Т.Өлзийсүрэн, нарийн бичгийн даргаар статистикийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Батхишиг нар ажиллав. Жилийн эцсийн мал тооллого 2017 оны 12-р сарын 07-ны өдрөөс 17-ны өдрүүдэд амжилттай явагдаж дууслаа.</p> <p>1.12.2. Мал тооллогыг сумдад зохион байгуулах ажилтнуудад зориулж 12 дугаар сарын 04-ний өдөр 18 сум 4 тосгодын 88 багийн засаг дарга, төрийн сангийн мэргэжилтэн нарыг оролцуулсан нийт 110 хүний сургалтыг АЗДТГазрын</p> | |

| | | |
|---|---|--|
| <p>зохион байгуулалтыг хангах</p> | <p>дэмжлэгтэйгээр онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулсан нь мал тооллогын сургалтанд зарцуулагдах 5814.4 мян.төгрөгийн зардлыг хэмнэлээ.</p> <p>1.12.3. Бүх суманд мал тооллогын маягтыг дагалдах маягтын хамт хуваарилан хүргүүлж тооллогын бэлтгэл ажлыг хангуулж, мал тооллогын комиссын гишүүдийн хурлыг 2017 оны 12 дугаар сарын 05-ны 10 цагт зохион байгуулж, аймгийн засаг даргын А/431 тоот захирамжийг танилцуулан комиссын гишүүдийн ажиллах маршрут удирдамжийг өгөв</p> <p>1.12.4. Мал тооллогын дүн мэдээг өрх бүрээр онлайн-аар шивэх бэлтгэл зохион байгуулалтыг хангах зорилгоор Бүх сумын интернетийн холболтыг найдвартай ажиллуулж сумдын удирдлагуудтай хамтран шивэлтийн ажлыг саадгүй хийхэд анхааран ажиллалаа.</p> | |
| <p>1.13. Статистикийн мэдээлэл тархаалтын ажлыг өргөжүүлэх;</p> | | |
| <p>1.13.1. Мэдээлэл тархаалтын хуваарийг батлан мөрдөх ба эмхэтгэл, товхимол, танилцуулгын нэгдсэн бүртгэлтэй болсон байна.</p> <p>1.13.2. ҮСХ-ноос боловсруулсан хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судлах зааврын дагуу хэрэглэгчдийг бүртгэж, эргэх холбоотой ажиллана.</p> <p>1.13.3. Мэдээллээр үйлчлэх электрон самбарын болон статистикийн хэлтсийн вэб сайтын мэдээллийг тогтмол баяжуулж хэрэглэгчдэд үйлчлэх</p> <p>1.13.4. Статистикийн мэдээллийн танилцуулга, судалгаа, эмхэтгэл, нугалбар зэргийг тухай бүр хэвлэн тархаана.</p> <p>1.13.5. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан Статистикийн байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, мэдээлэл тархаалт, ашиглалтын талаар өргөн сурталчилна.</p> | <p>1.13.1. Мэдээлэл тархаалт хариуцсан мэргэжилтэн сар бүр мэдээлэл тархаалтын тайлан бичиж эмхэтгэл, товхимол, танилцуулгын нэгдсэн бүртгэл хөтлөн ажиллаж байна.</p> <p>1.13.2. ҮСХ-ноос боловсруулсан хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судлах зааврын дагуу хэрэглэгчдийн бүртгэл хөтлөн тэдэнд хэрэгцээт мэдээллээр ханган ажиллалаа.</p> <p>1.13.3. Интернет хэрэглэдэг хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтаар сар бүр орж мэдээлэл авч байх талаар зөвлөмж өгч ажиллалаа. Интернетгүй хэрэглэгчдэд Devinfo сангийн хэрэглэгээг сурталчилах зорилгоор monsis 1212 cd 20 ширхэгийг тархааж, аймгийн ЗДТГ-ын үүдэнд байршуулж байсан цахим самбарыг Эвт худалдааны төвд байрлах Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд шилжүүлэн байршуулж мэдээллийг тогтмол шинэчилж иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа. Хэлтсийн facebook хуудсаар дамжуулан хэлтсийн хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүрт нь байршуулан сурталчлан ажиллаж байна. Веб хуудсанд хандсан хүний тоо 2017 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар 62.3 мянга байна. Хэлтсийн вэб сайтын цэсийг тухай бүр шинэчилэн ажиллаж байна</p> <p>2017 оны 10 дугаар сарын 05-нд “Khentii statistic” фейсбүүк хуудастай хамт “Хэнтий статистик” цахим хуудас нээн ажиллуулж эхэлсэн. 12 дугаар сарын 13-ны байдлаар цахим хуудасруу 2702 хүн хандсан байна. Цаг үеийн мэдээ мэдээллийг хэлтсийн вэбд байршуулахаас гадна фейсбүүк болон цахим хуудас ашиглан хэрэглэгчдэд хүргэж байгаа.</p> <p>1.13.4. Статистикийн сар бүрийн бюллетень, танилцуулгыг 248 ширхэг, Аймгийн статистикийн жилийн эцсийн эмхэтгэл 28 ширхэг, "Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтийн төлөв байдал" танилцуулга 35 ширхэг, "Ажил эрхлэлтийн байдал" танилцуулга 35 ширхэг, "Хөдөө аж ахуй" танилцуулга 50 ширхэг, "Аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарын танилцуулга" 25 ширхэг, "Худалдаа"</p> | |

| | | |
|---|--|--|
| <p>1.13.6. Хэвлэмэл бүтээгдэхүүн, зурагт хуудас бэлтгэн тархааж, сурталчилгааны самбараар байнгын мэдээллийг тавьж сурталчилна.</p> <p>1.13.7. Хэрэглэгчидтэй байнгын уулзалт, сургалт, сурталчилгааг зохион байгуулна.</p> | <p>танилцуулга 25 ширхэг тус тус хэвлэн тархаасан байна.</p> <p>1.13.5. Хэвлэлийн бага хурлыг сар бүрийн 15- 20-ны хооронд тогтмол хийж хэвшлээ. Нийт 12 удаа хийсэн байна. Үүнд аймгийн “Хэнтий”, “Өндөрхаан” телевизүүд, “Хэнтийн мэдээ” сонин, АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албыг тогтмол оролцуулж байна. Хэвлэлийн бага хуралд сар бүрийн гаргадаг нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгаар слайд бэлтгэн оролцож, цаг үеийн ажлын талаар мэргэжилтнүүд ээлжлэн оролцож мэдээлэл хийж ирлээ. ӨНЭЗС болон АХС-ны шторкыг “Хэнтий”, “Өндөрхаан” телевизүүдэд өгч 10 хоног өдөрт 10 удаагийн давталттайгаар 100 удаа эфирээр, мал тооллогын болон Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс шторкыг, “Өндөрхаан”, “Хэнтий” телевизээр болон facebook хуудсаар өдөрт 10 удаагийн давталттайгаар сард 15 хоног буюу давхардсан тоогоор 1500 удаа эфирээр цацууллаа.</p> <p>Энэ онд "Хэнтийн мэдээ" сонинтой 2017 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, 7 хоног тутам гардаг тус сонинд статистик мэдээллийн булан тогтмол ажиллаж, иргэд аймаг орон нутгийн талаарх төрөл бүрийн тоо баримт мэдээлэлтэй танилцаж ирлээ. Хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон лекц хэлбэрээр 18 сум 4 тосгоныг оролцуулан 70 аж ахуйн нэгж, 9.0 мянга гаруй хүнд сургалт сурталчилгааг хийсэн байна.</p> <p>1.13.6. ҮСХ-ноос гаргадаг “Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал” нугалбарыг аймгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж, байгууллага, сумд, иргэдэд нийт 225 ширхэгийг тархаав. Зөвлөлдөх санал асуулгын танилцуулга нугалбарыг 1000 ширхэгийг ААН байгууллагууд болон сумдууд, иргэдэд тархаалаа. Хэнтий аймгийн 3-р улирлын нийгэм эдийн засгийн байдлын инфографик, Монгол улсын нийгэм эдийн засгийн байдлын 3-р улирлын инфографикийг тус тус 200 ширхэг тараасан байна.</p> <p>1.13.7. Статистикийн алба үүсэн байгуулагдсны 93 жилийн ойг угтаж Статистикийн хэлтсийн үйл ажиллагааг таниулах, статистик мэдээллийн тархаалтыг сайжруулах, иргэдийн статистик мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 25-аас 11 дүгээр сарын 8-ыг дуустал хугацаатай Төрийн байгууллагуудыг хамруулсан аян зарласан. Энэ аяны хүрээнд аймгийн төвд үйл ажиллагаагаа явуулдаг төсвийн байгууллагууд болон төрийн өмчит үйлдвэрийн газрууд 33 байгууллагад очиж 550 гаруй хүнийг мэдээллээр хангасан байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв Эвт худалдааны төвийн 2 давхарт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион явууллаа. Өдөрлөгт 200 гаруй иргэд оролцов.</p> | |
| <p>2.1. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах;</p> | | |
| <p>2.1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны ҮСХ-ны 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.</p> <p>2.1.2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон</p> | <p>2.1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны ҮСХ-ны 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2.1.2. Хэлтсийн дарга болон ахлах мэргэжилтэн нар хөрөнгө орлогын мэдүүлгийг хууль дүрмийн дагуу хугацаанд нь программд шивж оруулан баталгаажуулж гарын үсэг зуран ҮСХ-д хүргүүллээ.</p> | |

| | | |
|---|---|--|
| хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гаргах ажлыг зохион байгуулна. | | |
| 2.2. Эдийн засгийн статистикийн сар, улирал, жилийн мэдээ (ХАА, АҮ, Барилга, Тээвэр, Зочид буудал, Зоогийн газар, Худалдааны зэрэг)-ний хамралт, үнэн, бодит байдалд хийх хяналтыг бие даан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах; | | |
| <p>2.2.1. Хэлтсийн даргын баталсан удирдамж, графикийг мөрдөнө.</p> <p>2.2.2. Хяналт шалгалт, мониторингоор илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг тухай бүр авч байна.</p> | <p>2.2.1. Хэлтсийн даргын баталсан графикийн дагуу сумд болон ААН-үүдээс мэдээнүүдийг цуглуулан авч боловсруулан ҮСХ-д цахимаар дамжуулж байна.</p> <p>2.2.2. Мэдээлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ хариуцагч нараас мэдээ хүлээн авах үед мэдээг урьд саруудын мэдээтэй харьцуулан алдаа оноог хэлж мэдээллийг үнэн зөв гаргах талаар хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Хэлтсийн мэргэжилтэн, судлаач нарын хариуцсан салбарын мэдээ, тайлан, судалгааны ирцийг сар бүр бүртгэн дүгнэн ажиллаж байна.</p> <p>ҮСХ-ны хяналт үнэлгээ мониторингийн хэлтсийн шинжээч Энхтүвшинд мэдээний маягтуудаа шалгуулан заавар зөвлөмж авч түүний дагуу ажлаа гүйцэтгэн ажиллаж байна.</p> | |
| 2.3. Хүн ам, нийгмийн салбарын статистикийн мэдээ тайланг тогтоосон хугацаанд чанартай гаргаж ирүүлэх; | | |
| <p>2.3.1. Батлагдсан маягт зааврын дагуу холбогдох мэдээллийг анхан шатны нэгжээс цуглуулж, нэгтгэх. Чанарын хяналт шалгалтыг хийж нэгтгэн дамжуулах.</p> <p>2.3.2. Анхан шатны мэдээлэлд чанарын хяналт шалгалт хийж алдаагүй мэдээллийг дамжуулах.</p> | <p>2.3.1. Батлагдсан заавар, маягтын дагуу анхан шатны нэгжээс цуглуулан нэгтгэж шалгаж боловсруулалтанд хяналт тавин ҮСХ-д дамжуулан ажиллаж байна.</p> <p>2.3.2. Анхан шатны мэдээлэлийг маягт тус бүрээр шалган тодруулгыг тухай бүрд нь хийж чанарын хяналт шалгалт хийж алдаагүй мэдээллийг ҮСХ-д дамжуулан ажиллалаа.</p> | |
| 2.4. ӨНЭЗС, АЗС, АХС-ны мэдээллийг цуглуулах боловсруулах, дамжуулах ажлыг чанартай зохион байгуулах; | | |
| <p>2.4.1. Баталсан үзэл баримтлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу мэдээллийн үнэн бодит байдлыг ханган цуглуулж, боловсруулна.</p> <p>2.4.2. Мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор бие даан болон бусад байгууллагатай хамтарсан хяналт, шалгалтыг хийнэ.</p> <p>2.4.3. Хяналт шалгалт, мониторингоор илрүүлсэн зөрчлийг</p> | <p>2.4.1. Аймаг, сум, багуудад ӨНЭЗСудалгааг үнэн зөв, бодитой, чанартай явуулах заавар, зөвлөмжийн дагуу судалгааны ажлыг зохион байгуулж явууллаа. Судлаач Г.Ангараг, Э.Нандинтуяа нартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, судлаач нарт судалгааны заавар журмыг нэг бүрчлэн судлуулж ажилласнаар судалгааны ажил өмнөх жилүүдээс чанартай ахицтай явагдав. ӨНЭЗСудалгааг 2017 онд дэлгэрэнгүй хэлбэртэйгээр таблет ашиглан авч ажиллалаа. Судалгааны ахлагч хяналтаар сар бүр 1 сумын 3-4 өрхийг бүрэн шалгаж, тоологчид тухай бүр зааварчилж ажилласнаар судалгааны хамралт 100%, чанар хангалттай түвшинд байна. ӨНЭЗСудалгаанд хамрагдсан 18 сумын 48 багийн 408 өрхийн 42 өрхөд шалгалт хийлээ. Мөн АХСудалгаанд хамрагдсан 18 сумын 36 багийн 432 өрхүүдээс 52 өрхөд хяналт хийж судалгааны чанар, үнэн зөв байдал, өрхөд олгогддог</p> | |

| | | |
|--|---|--|
| <p>арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулна.</p> | <p>урамшууллын мөнгө очиж байгаа эсэхийг шалгаж, судалгааны тоологч нарын ажлын чанарт үнэлгээ өгч ажилласан.</p> <p>2.4.2. ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч Болормаа, Анхзаяа нар ӨНЭЗС болон АХС-ны мониторингоор ажиллав. Судалгаанд хамрагдсан сумдуудаас Бор-Өндөр, Хэрлэн, Өмнөдэлгэр сумдыг сонгон нийт 30 өрхөөр орж хяналт хийсэн болно. Хяналтын үр дүнд судлаач нарт судалгааг илүү үр дүнтэй асуулга бүрээр нягт авах, асуулга орхигдуулахгүй, мөн асуултыг тухайн судлуулагчаар тайван бодож хариулахад хугацаа өгөх, хурдан түргэн асуухгүй байх, ямагт судалгааны урамшууллыг олгох, асуулгын уялдаа холбоог анхаарах зэрэгт зөвлөгөө өгж хамтран ажиллав. Судалгааны баг амжилттай шалгагдаж үр дүнгээр 4 оноо авсан.</p> <p>2.4.3. Хяналт шалгалт, мониторингоор илэрсэн зөрчилгүй анхаарч ажиллах зүйлүүдэд заавар зөвлөмж авлаа.</p> | |
| <p>2.5. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах;</p> | | |
| <p>2.5.1. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах төлөвлөгөө боловсруулна.</p> <p>2.5.2. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг цахим хуудас, мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд сурталчилж ажиллана.</p> <p>2.5.3. Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулна.</p> <p>2.5.4. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.</p> <p>2.5.5. Хэлтсийн хүний нөөцийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.</p> <p>2.5.6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хэлтсийн төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.</p> | <p>2.5.1. 2.5.2. Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах ажлын хүрээнд</p> <p>2.5.3. “Статистик таны хэрэглээ”- аяны хүрээнд нэг цэгийн үйлчилгээний төв Эвт худалдааны төвд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион явуулж байгууллагаа 200 гаруй хүнд сурталчиллаа.</p> <p>2.5.4. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Манай хэлтсийн 2017 онд Үндсэн дансны жилийн батлагдсан төсөв нь 72463,4 мянган төгрөг. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 59448.1 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 6191.6, Бараа үйлчилгээний зардалд 5291.4 мянган төгрөг, Тээврийн хэрэгслийн зардалд 355.5 мянган төгрөгийг зарцуулаад байна. Нэмэлт санхүүжилтийн данс буюу судалгааны зардлыг нэг бүрчлэн гүйцэтгэлээр нь харахад ӨНЭЗС, АХС-ны зардалд 35671,9 мянган төгрөг, ажилах хүчний туршилтын судалгаанд 959.5 мянган төгрөг, багын засаг дарга нарын сургалтын зардалд 10979,0 мянган төгрөг, малын ашиг шимийн судалгаанд 1194.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого хяналтын зардалд 10744.7 мянган төгрөг, жилийн эцсийн мал тооллого хяналтанд 4500.0 мянган төгрөг, эрчим хүч үйлдвэр үнийн хэрэглээний судалгаанд 1377,0 мянган төгрөг, зөвлөлдөх санал асуулгын судалгаанд 1503,0 мянган төгрөг, бусад төрлийн үнийн мэдээнд 4835,3 мянган төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>2.5.6. Шилэн дансны цахим хуудсанд тухай бүрт мэдээлэх 8, сар болгон 3, улирал болгон 1, хагас жил 4, бүтэн жилийн 11 мэдээллийг цаг хугацаанд сар болгоны 08-ны дотор иж бүрэн байршуулж ажиллаа.</p> <p>2.5.7. Мэргэжилтнүүд болон ажилтнуудад тухайн цаг үеийн болон ҮСХ, аймаг орон нутгаас өгч байгаа мэдээ мэдээллүүдийг тогтмол 1 дэх өдөр болгон хэлтсийн хурал</p> | |

| | | |
|--|--|--|
| <p>2.5.7. албан хаагчдад цаг үеийн байдал, хэрэгцээг харгалзан мэдээллийн цагийг хийнэ</p> <p>2.5.8. Хэлтэст ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллана</p> | <p>хийж танилцуулан санал солилцон ажиллаж байна.</p> <p>2.5.8. Манай хэлтэст 2017 онд иргэд болон байгууллагуудаас санал, хүсэлт, өргөдөл гомдол ирээгүй болно.</p> | |
| <p>2.6. Статистикийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;</p> | | |
| <p>2.6.1. Бие дааж болон бусад байгууллагуудтай хамтран тооллого, судалгааны үнэн бодит байдалд хяналт шалгалтыг холбогдох эрх зүйн баримтын дагуу зохион байгуулна.</p> <p>2.6.2. Хууль хяналтын байгууллагатай холбогдох чиглэлээр хамтран ажиллана.</p> | <p>2.6.1. Хэлтсээрээ бие дааж хийсэн шалгалт: Аж ахуйн нэгжид- 18, ӨНЭЗС, АХС, судалгааны мониторингоор нийт 94 өрхөд, мал тооллогын хяналт 560 өрхөд тус тус хийсэн байна. Аймгийн бусад байгууллагатай хамтарсан шалгалт 15-ыг хийлээ. Мал тооллого судалгаануудын хяналтаар 18 сум 88 багт хүрч мониторингоор ажилласан.</p> <p>7 хоногийн үнэ болон сарын үнийн мэдээ авдаг Хурх зах, Петровис, Өндөрхаан-Уул, Нутгийн дэлгүүр зэрэг зарим аж ахуйн нэгжүүдээр орж үнийн мэдээ тайланг тулган шалгаж заавар зөвлөгөө өглөө.</p> <p>Судалгааны ахлагч хяналтаар сар бүр 1 сумын 3-4 өрхийг бүрэн шалгаж, тоологчид тухай бүр зааварчилж ажилласнаар судалгааны хамралт 100%, чанар хангалттай түвшинд байна. ӨНЭЗСудалгаанд хамрагдсан 18 сумын 48 багийн 408 өрхийн 42 өрхөд шалгалт хийлээ. Мөн АХСудалгаанд хамрагдсан 18 сумын 36 багийн 432 өрхүүдээс 52 өрхөд хяналт хийж судалгааны чанар, үнэн зөв байдал, өрхөд олгогддог урамшууллын мөнгө очиж байгаа эсэхийг шалгаж, судалгааны тоологч нарын ажлын чанарт үнэлгээ өгч ажилласан.</p> <p>ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч Болормаа, Анхзаяа нар ӨНЭЗС болон АХС-ны мониторингоор ажилласан. Судалгаанд хамрагдсан сумдуудаас Бор-Өндөр, Хэрлэн, Өмнөдэлгэр сумдыг сонгон нийт 30 өрхөөр орж хяналт хийсэн болно. Хяналтын үр дүнд судлаач нарт судалгааг илүү үр дүнтэй асуулга бүрээр нягт авах, асуулга орхигдуулахгүй, мөн асуултыг тухайн судлуулагчаар тайван бодож хариулахад хугацаа өгөх, хурдан түргэн асуухгүй байх, ямагт судалгааны урамшууллыг олгох, асуулгын уялдаа холбоог анхаарах зэрэгт зөвлөгөө өгсөн юм. Судалгааны баг амжилттай шалгагдаж үр дүнгээр 4 оноо авсан.</p> <p>2.6.2. Аймгийн цагдаагийн газраас гэмт хэрэг болон хууль эрх зүйн талаар сургалт сурталчилгааг ирж хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байна.</p> | |
| <p>2.7. Хэлтсийн дотоод үйл ажиллагаанд хяналт тавих;</p> | | |
| <p>2.7.1 Албан хаагчдын сахилга хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлнэ.</p> | <p>2.5.1. Ажилчин албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж ажилчдыг лектор Наранбаатарын лекцэнд хамруулан ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүллээ.</p> | |

| | | |
|--|--|--|
| <p>2.7.2. Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн эргэлт, шийдвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана.</p> | <p>2.5.2. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 7 үндсэн чиглэлээр Хяналт үнэлгээ, мониторингийн хэлтсийн Ахлах шинжээч Б.Энхтүвшин, Энхцэцэг нар орон нутагт статистикийн үйл ажиллагаатай танилцаж, хэлтсийн дотоод ажилд хяналт хийж албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн эргэлт шийдвэрлэлт, хадгалалт, хамгаалалтын талаар заавар, зөвлөгөө авч түүний дагуу ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна</p> | |
| <p>3.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаар сарын танилцуулга бэлтгэх;</p> | | |
| <p>3.1.1. Тухайн сарын мэдээнд хамрагдсан бүх салбарын үзүүлэлтүүдээр танилцуулга бэлтгэнэ.</p> <p>3.1.2. Танилцуулгын ИТХ, ЗД, Тамгын газрын дэргэдэх хэлтэс албад болон бусад хэрэглэгчид, сумдад тархаасан байна.</p> | <p>Сар бүрийн танилцуулгыг дараахь салбар чиглэлээр хийж, дүгнэлт гаргаж танилцуулга гаргаж байна. Үүнд:</p> <p>Аймгийн үндсэн үзүүлэлтүүд Нийгмийн зарим үзүүлэлтүүд Аж үйлдвэр Өрх, хүн ам нийгмийн зарим үзүүлэлт Нийгмийн халамж Ажилгүйдэл Гэмт хэрэг Шүүх, онцгой байдлын үзүүлэлт Боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдийг сүүлийн 2-3 жилээр зэрэгцүүлэн гаргаж танилцуулгыг бэлтгэж байна. Сар бүр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтээр гаргасан мэргэжилтнүүдийн мэдээллээр хэвлэлийн бага хурлын пресентацийг 12 удаа бэлтгэн 12 удаа хэвлэлийн бага хурлыг уявуулж телевиз болон Хэнтий мэдээ сонинд мэдээ мэдээлэл өглөө.</p> <p>3.1.2. Статистикийн сар бүрийн бюллетень, танилцуулгын агуулгыг баяжуулан өргөжүүлж аймаг орон нутгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудад биет хэлбэрээр 248 ширхэг тархааж мэдээллээр хангаснаас гадна статистикийн хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг цахим хэлбэрээр 502 гаруй хүнд тархаасан байна.</p> | |
| <p>3.2. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэрэглэгчдэд зайлшгүй тархаах 4 танилцуулгыг бэлтгэх;</p> | | |
| <p>3.2.1. Шаардлагатай тоон мэдээллийг бэлтгэн холбогдох зэрэгцүүлэлт, харьцуулалт хийх судалгаа гаргах ба танилцуулга цахим болон хэвлэмэл байдлаар тархаагдана.</p> | <p>3.2.1. Хөдөө аж ахуй, Ажил эрхлэлт, Хүн ам, өрх, Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын гэсэн 4 танилцуулгыг тус бүр 200 ширхэгийг хэвлүүлэн аймгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад тархааснаас гадна цахим хэлбэрээр 225 аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд тархаасан байна.</p> <p>"Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтийн төлөв байдал" танилцуулга: "Хүн ам зүйн өнөөгийн байдал" танилцуулгыг 2009-2016 оноор сум, аймгийн дүнгээр гаргаж судалгаа хийсэн. Үүний дүнгээр танилцуулга бэлтгэн аймгийн удирдлагуудад болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд нийт 35 ширхэгийг хэвлэн өгсөн ба цахим хэлбэрээр 60 удаа тархаан ашиглуулж байна.</p> <p>"Ажил эрхлэлтийн байдал" танилцуулга: Ажил эрхлэлтийн судалгааг 2016 оноор хийж, танилцуулга бэлтгэн хэвлэмлээр аймгийн удирдлага, холбогдох хэлтэс, 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд 35 ширхэгийг, цахимаар 60 удаа тархаалаа.</p> | |

| | | |
|---|---|--|
| | <p>"Хөдөө аж ахуй" танилцуулга: 1995-2016 оноор хийж аймгийн удирдлагуудад танилцуулдаг ба аймгийн мянгат малчдын зөвлөгөөнд зориулж гаргадаг тусгай захиалгат бүтээгдэхүүн болсон. Мянгат малчдын судалгааг 1995-2016 оноор хийж аймгийн удирдлагууд болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд 50 ширхэгийг хэвлэн ашиглуулж байна. Электрон хэлбэрээр 100 удаа тархаалаа.</p> <p>"Аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарын танилцуулга": Барилга угсралт, их засварын ажлыг 2006-2016 оноор гаргаж танилцуулга бэлтгэн 25 ширхэгийг хэвлүүлэн аймгийн удирдлагууд болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд тархаалаа. Цахимаар 30 удаа тархаав.</p> <p>"Худалдаа" танилцуулга: 2006-2016 оны худалдааны салбарын нийт гаргалт дээр динамик хандлагын шинжилгээ хийж танилцуулга бэлтгэн хэвлүүлж аймгийн удирдлагууд болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд 25 ширхэгийг, цахимаар 25 удаа тархаалаа.</p> | |
| <p>4.1. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах</p> | | |
| <p>4.1.1. Хэрэглэгчдэд зориулсан сургалтыг нутгийн төр, захиргааны байгууллагын ажилтнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд болон иргэдэд зохион байгуулна.</p> <p>4.1.2. Сургалтын тайланг баримтжуулан ҮСХ-нд хүргүүлнэ.</p> | <p>4.1.1. 2017 онд 5 төрлийн сургалт зохион явуулж нийт 847 хүнийг хамруулав. Баг, сумын ажилтнуудад зориулсан сургалт, Аймгийн төвийн 33 албан байгууллагын ажилтнуудад, ерөнхий боловсролын 4 сургуулийн төгсөх ангийн сурагчдад, МСҮТ-ийн төгсөх ангийн сурагчид болон иргэдэд сургалт зохион явууллаа.</p> <p>1.1.2. Өөрсдийн зохион явуулсан сургалтын тайланг тавьсан илтгэлүүдийн хамт тухай бүр ҮСХ-нд хугацаанд нь хүргүүлсэн болно.</p> | |
| <p>5.1. Статистикийн мэргэжлээр суралцаж буй хүний нөөцийн бүртгэл, судалгааг баяжуулсан байх;</p> | | |
| <p>5.1.1. Тухайн аймаг, сумын статистикийн чиглэлээр суралцаж, төгссөн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг баяжуулж өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн байна.</p> <p>5.1.2. Тухайн аймгаас статистикийн мэргэжлээр Улсын болон хувийн их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудын судалгааг гаргана.</p> | <p>5.1.1. Хэнтий аймгаас статистикийн чиглэлээр их дээд сургууль төгссөн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг баяжуулж энэ жил төгссөн 3 хүүхдийг нэмж бүртгэн авлаа. Мөн статистикийн мэргэжлээр сургууль төгсөгчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг ҮСХ-д гаргаж хүргүүллээ.</p> <p>5.1.2. Хэнтий аймгаас статистикийн мэргэжлээр Улсын болон хувийн их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудын судалгааг гаргахаар аймгийн боловсрол соёлын газарт хандаад байна.</p> | |
| <p>5.2. Сургалт, семинар зохион байгуулах замаар боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх;</p> | | |

| | | |
|--|--|--|
| <p>5.2.1. ҮСХ болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинарт албан хаагчдыг хамруулна.</p> <p>5.2.2. Хэлтсийн хэмжээнд сургалт, семинарыг өөрсдийн нөөц бололцоогоор зохион байгуулна.</p> <p>5.2.3. Статистикийн үйл ажиллагаатай холбоотой шинээр батлагдан гарсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, дүрэм, журмын талаарх сургалт, семинарыг зохион байгуулна.</p> <p>5.2.4. Шинээр ажилд орж буй албан хаагчдад Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Үндэсний статистикийн хорооны хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмын талаар сургалт явуулна.</p> <p>5.2.5. Статистикийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор иргэдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулна.</p> <p>5.2.6. Баг, хорооны түвшинд статистикийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалтыг зохион байгуулна.</p> <p>5.2.7. Ажилтнуудыг хөрвөх чадварыг дээшлүүлэх зорилгоор сэлгэн ажиллуулах арга хэмжээг зохион</p> | <p>5.2.1. Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр орон нутгийн статистикийн болон хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан боловсруулсан “Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй” сэдэвт сургалтанд 2017 оны 4 дүгээр сарын 13, 14-ны өдрүүдэд, “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөр”-ийн хүрээнд үнэ цуглуулагчдад зориулсан сургалтанд 2017 оны 5 дугаар сарын 23,24-ний өдрүүдэд тус тус мэргэжилтэн Б.Онончимэг оролцсон.</p> <p>Хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Наранчимэг нь: - ҮСХ-д очиж ЭХҮХ-ний 2015, 2016 оны судалгааны тоологчийн сургалтанд 2 хоног суув. Аймгаас тус судалгаанд ажиллах 2 хүнийг авч сургалтанд суулган ажиллууллаа.</p> <p>АЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс явуулсан хяналт шинжилгээ үнэлгээний сургалтанд 1 хоног суулаа.</p> <p>АЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран зохион явуулсан Төрийн албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх сургалтанд хамрагдан 12 цагийн хичээлд тус тус амжилттай сууж батламжлах гэрчилгээ авлаа.</p> <p>Статистикийн төв орон нутгийн байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх анхан шатны 48 цагийн сургалтанд гэрээт мэргэжилтэн А.Мөнх-Уянга амжилттай суралцаж сертификат, Тод санхүү группын 8 цагын сургалтанд амжилттай хамрагдаж сертификат тус тус гардан авсан.</p> <p>Хэлтсийн нягтлан бодогч А.Мөнх-Уянга нь Монголын нягтлан бодох бүртгэлийн холбоонд гишүүнээр элсэж нягтлан бодогчийн тангараг өргөв.</p> <p>5.2.2. Ажилчин албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж ажилчдыг лектор Наранбаатарын лекцэнд хамруулан ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүллээ.</p> <p>Статистикийн хэлтсээс ажилтнуудын дунд явуулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлгийг 2017 оны 8-р сарын 10-ны өдөр хэлтсийн мэргэжилтнүүдийн өрөөнд явууллаа.</p> <p>Хэлэлцүүлгийг ахлах мэргэжилтэн А.Наранчимэг удирдан явуулав. Хэлэлцүүлэгт: хэлтсийн дарга Т.Өлзийсүрэн, мэргэжилтэн Ц.Батхишиг, Б.Онончимэг, Г.Сэдэдмаа, гэрээт ажилтан А.Мөнх-Уянга, судлаач Э.Нандинтуяа, Г.Ангараг, жолооч Б.Соронзонбаатар, ахлах мэргэжилтэн А.Наранчимэг нар оролцов.</p> <p>5.2.3. 5.2.5. Статистикийн үйл ажиллагаатай холбоотой шинээр батлагдан гарсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, дүрэм, журмын талаарх сургалт, семинарыг 33 байгууллагын 550 гаруй хүнд зохион байгууллаа.</p> <p>5.2.4 Шинээр судлаачаар ажилд орсон Нандинтуяа, гэрээт мэргэжилтэн А.Мөнх-Уянга, жолооч Я.Ганзориг нарт Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Үндэсний статистикийн хорооны хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмын талаар танилцуулан тайлбарлаж өглөө.</p> | |
|--|--|--|

| | | |
|--|---|--|
| байгуулна. | <p>5.2.6. Үндэсний Статистикийн хороо, аймгийн Статистикийн хэлтэс хамтран зохион байгуулж буй Баг хорооны Засаг дарга, сумдын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалтанд нийт 18 сумын 88 багийн дарга, сумдын статистик хариуцсан төрийн сангийн мэргэжилтэн 22, нийт 110 хүн хамрагдлаа.</p> <p>5.2.7. Ажилтнуудын хөрвөх чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжилтэн Ц.Батхишигийг сургуульд суралцах хугацаанд мэргэжилтэн Г.Сэдэдмаа ,Онончимэг, А.Наранчимэг нар мэдээнүүдийг нь хуваан авч ажиллаж байлаа.</p> | |
| <p>5.3. Цаг үеийн шаардлагаар ҮСХ-ноос эдийн засгийн статистик болон хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь цуглуулж, дамжуулах;</p> | | |
| <p>5.3.1. Маягт, заавар, аргачлалын дагуу мэдээллийг цуглуулна.</p> <p>5.3.2. Мэдээллийг тогтоосон хугацаанд дамжуулна.</p> | <p>Биеийн тамир, спортын улсын нэг удаагийн үзлэг тооллогын ажлын талаарх онлайн сургалтанд 2 удаа суун, Спорт хорооны мэргэжилтэнд маягт заавар, аргачлалын дагуу судалгаа явуулах арга зүйн зөвлөгөө өгөн ажиллалаа.</p> <p>Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцооны суурь мэдээллийг шинэчлэх судалгаанд сонгогдсон Хэнтий-Ус ХХК, Хөвчийн жонон ХХК-уудаас маягт заавар, аргачлалын дагуу судалгааг авч хугацаанд нь ҮСХ-д дамжуулан ажиллалаа.</p> <p>ҮСХ-ноос шаардсан мэдээ мэдээлэл, тодруулгыг цаг тухай бүрд нь маягт зааврын дагуу цуглуулан авч мэйлээр болон цаасан хэлбэрээр бэлтгэж ҮСХ-д тогтоосон хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Мөн төвөөс ирсэн заавар журмуудтай танилцаж ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> | |
| <p>5.4. Шинээр байгуулагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний мэдээллийг тухай бүр албан ёсны мэдээлэлд хамруулна;</p> | | |
| <p>5.4.1. Улирал бүр улсын бүртгэлийн хэлтэс, сумдын татварын байцаагч нартай хамтарч шинээр байгуулагдсан болон регистрийн санд бүртгэгдээгүй аж ахуйн нэгжийг тогтоож маягт, үзүүлэлтийн дагуу бүртгэн ҮСХ-нд мэдээлнэ.</p> | <p>5.4.1. Бизнес регистрийн санд улирал болон жилийн эцэст бизнес регистрийн мэдээ гаргах аж ахуйн нэгжүүдийн нэрсийг тодруулан, үндсэн газруудаас маягтын дагуу мэдээг гаргуулан авч хяналт тавин ажиллалаа.</p> <p>Жилийн эцсийн мэдээний тодруулгад 1536-н аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулахаас 100 хувь бүрэн хамруулж тодруулга тайлбар хийж хугацаанд нь ҮСХ-д хүргүүлсэн.</p> <p>2017 онд БР-ийн санд 112 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж бизнес регистрийн санг цэгцэлж, татан буугдсан, давхардаж бүртгэгдсэн аж ахуйн нэгжийг хасч санг шинэчлэв. Тайлант хугацаанд Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, хаяг, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тоо зэргийг шинэчлэн орууллаа. Энэ ажлын хүрээнд байгууллагын мэдээллийг шинэчиллээ. Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ААН байгууллагыг Статистикийн хэлтсээс тойрох авч шинээр бүртгэдэг болсон нь үр дүнгээ өгч байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор бизнес регистрийн сангийн өөрчлөлтөнд 112 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж хамруулахаас 112 нэгжийг хамруулж баяжилтыг 100 хувь хийлээ.</p> | |

| | | |
|--|---|--|
| 5.5. Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд амьдралын судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | |
| 5.5.1. Судалгааг зохион байгуулахад орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлж ажиллана. | 5.5.1. Үндэсний статистикийн хорооноос анх удаа зохион байгуулж буй “Эмэгтэйчүүд эрүүл мэнд, амьдралын туршлага” судалгаанд манай аймгийн 14 сумын 300 өрх сонгогдож ҮСХ-ноос судалгааны 2 баг ирж ажиллав. Тэднийг сум багийн засаг дарга нартай холбон өгч хөтөчөөр хэлтсийн мэргэжилтэн Г.Сэдэмаа гэрээт мэргэжилтэн А.Мөнх-Уянга нар ажиллалаа. | |
| 5.6. Статистикийн бизнес регистрийн сангийн чанарыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх; | | |
| 5.6.1. Статистикийн бизнес регистрийн сангийн чанарт анхаарч ажиллана. | 5.6.1. 2017 онд БР-ийн санд 112 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж регистрийн санг цэгцэлж, татан буугдсан, давхардаж бүртгэгдсэн аж ахуйн нэгжийг хасч санг шинэчлэв. Тайлант хугацаанд Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, хаяг, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тоо зэргийг шинэчлэн орууллаа. Энэ ажлын хүрээнд байгууллагын мэдээллийг шинэчиллээ. Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ААН байгууллагыг Статистикийн хэлтсээс тойрох авч шинээр бүртгэдэг болсон нь үр дүнгээ өгч байна | |
| 5.7. “Хүн ам, өрх”-ийн мэдээллийн сангийн баяжилтыг сумын түвшинд сайжруулан үйл ажиллагаандаа ашиглах; | | |
| 5.7.1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сум, багийн түвшинд баяжуулахад хяналт тавин ажиллана. | 5.7.1. ХАӨМС-н ажлын хүрээнд ҮСХ-с ирүүлсэн 3 удаагийн тодруулга,хүн амын үзүүлэлт, өрхийн үзүүлэлтийн алдааг тухай бүрд нь авч ялган 18 сум сум, 88 багт цахимаар хүргүүлэн алдааг засуулах ажил явагдаж байна. Засагдаагүй үлдсэн алдаа нь шилжиж ирсэн болон баталгаажигдаагүй өрх, түр эзгүй гэсэн хувь хүний алдаа үлдсэн байна энэ тухай тайлбарыг нь цаг хугацаанд нь ҮСХ-д хүргүүлэн ажиллалаа. ҮСХ-ны ХАОСТТ-ны Газарзүйн мэдээллийн систем хариуцсан ахлах мэргэжилтэн З.Нямбаяр, хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Наранчимэг нар Хэрлэн сумын 8 багийн зохион байгуулагч нарыг цуглуулан тэдний ХАӨМС-д байгаа алдаа, тэдэнд анхаарч ажиллах талаар мэдээлэл хийж заавар чиглэл өгч ажиллалаа. Энэ ажлын хүрээнд Хэрлэн сумын 5-р баг, 1-р багийн зохион байгуулагч нарт цаашид анхаарч ажиллах талаар сануулга өглөө. | |
| 5.7.2. Мэдээллийн сангийн нууцлалыг ханган үйл ажиллагаандаа ашиглах ажлыг өргөжүүлнэ. | ХАӨМС-н ажлын хүрээнд өрхийн байршил тогтоох цэг хатгалтын ажлыг эрчимтэй явуулсны дүнд 100 хувийн гүйцэтгэлээр бүрэн тэмдэглэж дууссан боловч одоогийн байдлаар шинээр шилжиж ирсэн болон баталгаажилт хийгдээгүй өрхүүдээс шалтгаалж өрхийн цэг хатгалт хийгдээгүй байна. Энэ талаар сумдын багийн дарга нарт үүрэг даалгавар өгөн ажиллалаа. Сумдын статистик хариуцсан ажилтан, багийн дарга нар шинээр ажил авч байгаатай холбогдуулан ХАӨМС-н тухай болон ХАӨМС-н программ хангамж, ХАӨМС- дээрх алдааг хэрхэн багийн дарга нараар засуулах талаар сургалтыг 1 удаа хийж 18 сум 4 тосгоны давхардсан тоогоор нийт 106 хүнийг хамруулж сургалттай холбогдож гарсан санал асуулгад дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Сумдын статистик хариуцсан ажилтан болон багийн дарга нарыг шинэ төрсөн хүүхэд болон нас баралт, шилжилт хөдөлгөөн, ХАӨМС-н баяжилтыг тухай бүрд нь хийж гүйцэтгэж байх үүрэг даалгавар өгөн ажиллаж байна. Багийн дарга нар ХАӨМС-д 1213 шинэ төрсөн хүүхэд бүртгэн авч 420 хүний нас баралтыг бүртгэн хасалт хийсэн байна. ХАӨМС-н ажлын хүрээнд 18 сум 88 багийн 10349 алдааг | |

| | | |
|---|---|--|
| | <p>хугацаатай үүрэг өгөн засуулж, байршил тогоогоогүй 761 өрхийн байршлыг тогоолгон, 336 ургийн овгийн алдааг ҮСХ-д өгч зөв ургийн овгоор засуулан алдааг устгуулан ажиллаа.</p> <p>5.7.2. Багийн дарга болон сумдын статистик хариуцсан ажилтнуудад ХАӨМС-н нууцлалыг ханган үйл ажиллагаандаа ашиглаж шаардлагатай тоон мэдээллийг авч ажиллах талаар сургалт хийлээ. Цаашид өдөр тутмын үйл ажиллагаандаа анхаарч ажиллахыг анхааруулж байнга заавар зөвлөмж өгөн ажиллаж байна.</p> | |
| <p>5.8. Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллах;</p> | | |
| <p>5.8.1. Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> | <p>5.8.1. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 7 үндсэн чиглэлээр Хяналт үнэлгээ, мониторингийн хэлтсийн Ахлах шинжээч Б.Энхтүвшин, Энхцэцэг нар орон нутагт статистикийн үйл ажиллагаатай танилцаж, хэлтсийн дотоод ажилд хяналт хийж архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар заавар, зөвлөгөө өглөө. Зөвлөмжийн дагуу ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> | |
| <p>5.9. Албан хаагчдын ажиллах таатай орчин, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> | | |
| <p>5.9.1. Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс биеийн тамир, спорт, соёл, олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөө гарган зохион байгуулна.</p> <p>5.9.2. Хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, шижилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулна.</p> <p>5.9.3. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай эд хогшил, техник хэрэгсэлээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p> | <p>5.9.1. Хэлтсийн ажилчдынхаа гэр бүлийн хамт чөлөөт цагаараа эрүүл цэвэр агаарт гарч цасны баяр тэмдэглэн өнгөрүүллээ.</p> <p>Албан хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилтын дүнд хамт олноороо Сүрхбаатар аймаг орж туршлага судлан байгалийн сайхныг үзэн аялаад ирэв.</p> <p>Жил болгон уламжлал болгон зохион байгуулдаг хэлтсийн нэрэмжит волейболын тэмцээнийг зохион байгуулав. Долоо хоногийн 3 дахь өдөр болгон зохион явуулдаг спортын арга хэмжээнд байгууллага хамт олноороо оролцож байна.</p> <p>5.9.2. Хамт олноо Эрүүл монгол хөтөлбөрийн хүрээнд үнэ төлбөргүй үзлэгт оруулж элэгний В,С вирусны шинжилгээнд хамруулав.</p> <p>5.9.3. Албан хаагчдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэхэд Ассемийн Азийн хөгжлийн хэмжээний чуулганд хандиваар бии болсон албан хэрэгцээнд ашиглаж байгаа хөрөнгөнөөс 19 ширхэг 2536000 мянган төгрөгийн нэр бүхий тавилга эд хогшил, ҮСХ-ноос 2 ш компьютер, 1 ш принтер авч ажилтнуудыг техник хэрэгслээр хангуулан ажиллаж байна.</p> | |
| <p>Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p> | | |

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

| <p><i>Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрсэн түвшин</i></p> | <p><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p> | <p><i>Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p> |
|--|--|---|
| 1 | 2 | 3 |
| <p>1.2. “Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх</p> | | |
| <p>1.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ажиллана.</p> <p>1.2.2. Хэрэгжилтийг ҮСХ-нд тайлагнана.</p> | <p>“Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд статистикийн салбарын нэгдсэн сүлжээг байгуулж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн ашиглаж байна.</p> | |
| <p>1.4. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах</p> | | |

| | | |
|---|---|--|
| <p>1.4.1. Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн болон биет хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, өмч хөрөнгийн тооллого явуулна.</p> <p>1.4.2. 2017 оны төсвийн төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог хангаж ажиллана.</p> <p>1.4.3. Жилийн эцсийн 2017 оны санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд гаргана.</p> <p>1.4.4. 2018 оны төсвийн төслийг боловсруулж, ҮСХ-нд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.</p> <p>1.4.5. Төсөв, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой ажил санаачлан зохион байгуулна.</p> | <p>1.4.1. Үндсэн дансны жилийн батлагдсан төсөв нь 72463.4 мянган төгрөг. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 59448.1 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 6191.6, Бараа үйлчилгээний зардалд 5291.4 мянган төгрөг, Тээврийн хэрэгслийн зардалд 355.5 мянган төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>Өмч хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр явуулан ажилтан нэг бүрийн эд хөрөнгийн картыг шинэчилж өглөө.</p> <p>1.4.2. 2017 оны төсвийн төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог ханган ажиллаж 2017 оны төсвийн гүйцэтгэлээр өр төлбөргүй гарлаа.</p> <p>1.4.3. Жилийн эцсийн 2017 оны санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд нь гаргахад бэлэн болоод байна.</p> <p>1.4.4. 2018 оны төсвийн төслийг боловсруулан гаргаж ҮСХ-ны санхүүгийн хэлтэст заасан хагацаанд нь гаргаж хүргүүллээ.</p> <p>1.4.5. Төсөв зардлыг бууруулах чиглэлээр</p> | |
| <p>1.5. ҮСХ-ны даргын 2016 оны А/79 тоот тушаалаар баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар цуглуулж, дамжуулах;</p> | | |
| <p>1.5.1. Улсын хэмжээний 8 тооллого, судалгаа болон албан ёсны статистикийн 46 төрлийн мэдээ, тайланг маягтын дагуу мэдээллийг цуглуулж, дамжуулна.</p> <p>1.5.2. Мэдээний маягт, заавар, аргачлалыг сум, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, мэдээ цуглуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>1.5.3. Ажилтан бүр цуглуулсан мэдээллийг маягт бүрээр нэг бүрчлэн шалгаж,</p> | <p>1.5.1. Үндэсний Статистикийн Хорооны даргын мэдээ тайлангийн график батлах тухай 2016 оны 12-р сарын 28-ны өдрийн А/79 тоот тушаалаар баталсан албан ёсны статистикийн 54 мэдээ тайлан гаргахаас аймгийн хэмжээнд гаргах 46 мэдээ тайлан, захиргааны 18 төрлийн мэдээ тайлан, 8 судалгааг 9388 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 10825 удаа авч шалгаж боловсруулан 275 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 275 удаа графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа.</p> <p>1.5.2. Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны “Албан ёсны статистик мэдээний график”-ийг шинэчлэн баталсан А/79 дүгээр тушаалыг үндэслэн аймгийн хэмжээнд мэдээлэх “Статистик мэдээний график”-ийг хэлтсийн дарга батлан сумд болон мэдээлэгч нарт хүргэж, хэрэгжилтийг ханган сум, ААНБ-аас мэдээ тайланг цуглуулан боловсруулж дамжууллаа.</p> <p>1.5.3. Мэдээний маягт, заавар, аргачлалыг 18 сум, 4 тосгон, 600 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад онлайн болон цаасаар хүргүүлэн, мэдээ цуглуулах ажлыг зохион байгуулан Оны эхэнд сумдад албан ёсны статистикийн мэдээ тайлангийн графикийг шинэчлэн хүргүүлж, графикийн биелэлт, мэдээний ирцийг сар бүр бүртгэж ажиллалаа.</p> | |

| | | |
|---|--|--|
| <p>алдаг засаж, протокол хөтөлнө.</p> <p>1.5.4. Мэдээллийг салбар бүрээр, программаар нэгтгэн боловсруулна.</p> <p>1.5.5. Мэдээллийг электрон хэлбэрээр графикт хугацаанд нь Ерөнхий газарт дамжуулна.</p> <p>1.5.6. Маягт бүрээр мэдээ тайланг цуглуулсан, дамжуулсан талаарх бүртгэлийг хөтөлсөн байна</p> | <p>1.5.4. Мэргэжилтэн бүр хариуцсан салбарын мэдээг цуглуулан нэгтгэн боловсруулж мэдээллийг сар, улирал, жилийн эцсийн программуудад оруулан шивж ҮСХ-д графикт хугацаанд нь хоцрогдолгүй дамжуулж ирлээ.</p> <p>1.5.5. 9388 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 10825 удаа авч шалгаж боловсруулан 275 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 275 удаа графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа.</p> <p>1.5.6. Мэргэжилтэн бүр өөр өөрсдийн хариуцсан салбарын мэдээ тайланг цуглуулан дамжуулсан талаар бүртгэл хөтөлж мэдээллийн сан үүсгэн хадгалж, ахлах мэргэжилтэн мэдээд мжуулалтын ирц бүртгэн ажиллаж байна. Энэний үр дүнд мэдээний хоцрогдолгүй ажиллалаа.</p> | |
| <p>1.7. Аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын хэрэгцээнд шаардлагатай захиргааны статистикийн мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийх;</p> | | |
| <p>1.7.1. Мэдээллийг 40 маягтын дагуу мэдээлэгчдээс цуглуулна.</p> <p>1.7.2. Мэдээллийг боловсруулан хянаж, нэгтгэн эмхэтгэл, танилцуулгаар тархаана</p> | <p>1.7.1. Сарын танилцуулгын мэдээллийг 40 маягтын дагуу мэдээлэгч байгууллагуудаас авч цуглуулан боловсруулна. Үүнд: Аймгийн үндсэн үзүүлэлтүүд, Нийгмийн зарим үзүүлэлтүүд, Аж үйлдвэр, Өрх, хүн ам нийгмийн зарим үзүүлэлт, Нийгмийн халамж, Нийгмийн даатгал, Ажилгүйдэл, Гэмт хэрэг, Шүүх, онцгой байдлын үзүүлэлт, Мэргэжлийн хяналт, Банк, холбоо, тээвэр, төсөв санхүү, Боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдийг сүүлийн 2-3 жилээр зэрэгцүүлэн гаргасан.</p> <p>1.7.2. Статистикийн сар бүрийн бюллетень, танилцуулгын агуулгыг баяжуулан өргөжүүлж аймаг орон нутгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудад биет хэлбэрээр 256 ширхэг тархааж мэдээллээр хангаснаас гадна статистикийн хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг цахим хэлбэрээр 300 гаруй хүнд тархаасан байна.</p> | |
| <p>1.8. Хөдөө аж ахуйн 2017 оны завсрын тооллогыг зохион байгуулах</p> | | |
| <p>1.8.1. Баталсан үзэл баримтлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу мэдээллийн үнэн бодит байдлыг ханган цуглуулж, боловсруулна.</p> <p>1.8.2. Мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор бие даасан болон бусад байгууллагатай хамтарсан хяналт,</p> | <p>1.8.1. Хөдөө аж ахуйн завсрын тооллогыг 2017 оны 11 сарын 06-аас 12 сарын 10-ны хооронд Хэнтий аймгийн 18 сумын 88 багийн 5338 өрх, 53 аж ахуйн нэгжийг хамруулан баталсан үзэл баримтлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгууллаа. Тооллогод хамрагдсан өрх, ААН-үүд бүгд батлагдсан маягт, зааврын дагуу мэдээлэлээ өгөв.</p> <p>1.8.2. Мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор сумдаас ирж байгаа маягыг хянан шалгаж хүлээн авлаа..</p> | |

| | | |
|--|--|--|
| <p>шалтгалтыг хийнэ. 1.8.3. Хяналт шалгалт, мониторингоорилруулсэн зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулна.</p> | <p>1.8.3. Тооллогын маягт хянах явцад гарсан асуудлыг тодруулан засаж онлайн программд шивж оруулан хугацаанд нь ҮСХ-д дамжууллаа</p> | |
| <p>1.12. Мал тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулах;</p> | | |
| <p>1.12.1. Малын хагас, бүтэн жилийн тооллогыг явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна. 1.12.2. Мал тооллогыг сумдад зохион байгуулах ажилтнуудын сургалт, семинар /аргачлал болон программ зэрэг/-ыг явуулах. 1.12.3. Малын тооллогыг оновчтой зохион багуулах мэргэжлийн удирдлагаар хангана. 1.12.4. Мал тооллогын дүн мэдээг өрх бүрээр онлайнаар шивэх бэлтгэл зохион байгуулалтыг хангах</p> | <p>1.12.1. Эхний хагас жилийн мал тооллого, түүвэр судалгааг 2017 оны 6 сарын 15 наас эхлэн хуулийн дагуу 7 хоног орон даяар зохион байгууллаа. Тооллого түүвэр судалгаанд Хэнтий аймгийн бүх сумдыг хамруулан нийт малчин өрхийг төлөөлөх чадвар бүхий 1532 өрхүүдийг түүвэрлэн тооллого явуулав. Аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/431 тоот захирамжаар жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг 13 гишүүнтэй томиллоо. Аймгийн комиссын даргаар аймгийн засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун, орлогч даргаар Статистикийн хэлтсийн дарга Т.Өлзийсүрэн, нарийн бичгийн даргаар статистикийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Батхишиг нар ажиллав. Жилийн эцсийн мал тооллого 2017 оны 12-р сарын 07-ны өдрөөс 17-ны өдрүүдэд амжилттай явагдаж дууслаа. 1.12.2. Мал тооллогыг сумдад зохион байгуулах ажилтнуудад зориулж 12 дугаар сарын 04-ний өдөр 18 сум 4 тосгодын 88 багийн засаг дарга, төрийн сангийн мэргэжилтэн нарыг оролцуулсан нийт 110 хүний сургалтыг АЗДТГазрын дэмжлэгтэйгээр онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулсан нь мал тооллогын сургалтанд зарцуулагдах 5814.4 мян.төгрөгийн зардлыг хэмнэлээ. 1.12.3. Бүх суманд мал тооллогын маягтыг дагалдах маягтын хамт хуваарилан хүргүүлж тооллогын бэлтгэл ажлыг хангуулж, мал тооллогын комиссын гишүүдийн хурлыг 2017 оны 12 дугаар сарын 05-ны 10 цагт зохион байгуулж, аймгийн засаг даргын А/431 тоот захирамжийг танилцуулан комиссын гишүүдийн ажиллах маршрут удирдамжийг өгөв 1.12.4. Мал тооллогын дүн мэдээг өрх бүрээр онлайнаар шивэх бэлтгэл зохион байгуулалтыг хангах зорилгоор Бүх сумын интернетийн холболтыг найдвартай ажиллуулж сумдын удирдлагуудтай хамтран шивэлтийн ажлыг саадгүй хийхэд анхааран ажиллалаа.</p> | |
| <p>2.7. Хэлтсийн дотоод үйл ажиллагаанд хяналт тавих;</p> | | |

| | | |
|--|---|--|
| <p>2.7.1 Албан хаагчдын сахилга хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлнэ.</p> <p>2.7.2. Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн эргэлт, шийдвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана.</p> | <p>2.7.1. Ажилчин албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж ажилчдыг лектор Наранбаатарын лекцэнд хамруулан ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүллээ.</p> <p>2.7.2. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 7 үндсэн чиглэлээр Хяналт үнэлгээ, мониторингийн хэлтсийн Ахлах шинжээч Б.Энхтүвшин, Энхцэцэг нар орон нутагт статистикийн үйл ажиллагаатай танилцлаа. Хэлтсийн дотоод ажилд хяналт хийж албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн эргэлт шийдвэрлэлт, хадгалалт, хамгаалалтын талаар заавар, зөвлөгөө авч түүний дагуу ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> | |
| <p>3.2. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэрэглэгчдэд зайлшгүй тархаах 4 танилцуулгыг бэлтгэх;</p> | | |
| <p>3.2.1. Шаардлагатай тоон мэдээллийг бэлтгэн холбогдох зэрэгцүүлэлт, харьцуулалт хийх судалгаа гаргах ба танилцуулга цахим болон хэвлэмэл байдлаар тархаагдана.</p> | <p>3.2.1. Хөдөө аж ахуй, Ажил эрхлэлт, Хүн ам, өрх, Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын гэсэн 4 танилцуулгыг тус бүр 200 ширхэгийг хэвлүүлэн аймгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад тархааснаас гадна цахим хэлбэрээр 225 аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд тархаасан байна.</p> <p>"Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтийн төлөв байдал" танилцуулга: "Хүн ам зүйн өнөөгийн байдал" танилцуулгыг 2009-2016 оноор сум, аймгийн дүнгээр гаргаж судалгаа хийсэн. Үүний дүнгээр танилцуулга бэлтгэн аймгийн удирдлагуудад болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд нийт 35 ширхэгийг хэвлэн өгсөн ба цахим хэлбэрээр 60 удаа тархаан ашиглуулж байна.</p> <p>"Ажил эрхлэлтийн байдал" танилцуулга: Ажил эрхлэлтийн судалгааг 2016 оноор хийж, танилцуулга бэлтгэн хэвлэмлээр аймгийн удирдлага, холбогдох хэлтэс, 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд 35 ширхэгийг, цахимаар 60 удаа тархаалаа.</p> <p>"Хөдөө аж ахуй" танилцуулга: 1995-2016 оноор хийж аймгийн удирдлагуудад танилцуулдаг ба аймгийн мянгат малчдын зөвлөгөөнд зориулж гаргадаг тусгай захиалгат бүтээгдэхүүн болсон. Мянгат малчдын судалгааг 1995-2016 оноор хийж аймгийн удирдлагууд болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд 50 ширхэгийг хэвлэн ашиглуулж байна. Электрон хэлбэрээр 100 удаа тархаалаа.</p> <p>"Аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарын танилцуулга": Барилга угсралт, их засварын ажлыг 2006-2016 оноор гаргаж танилцуулга бэлтгэн 25 ширхэгийг хэвлүүлэн аймгийн удирдлагууд болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд тархаалаа. Цахимаар 30 удаа тархаав.</p> <p>"Худалдаа" танилцуулга: 2006-2016 оны худалдааны салбарын нийт гаргалт дээр динамик хандлагын шинжилгээ хийж танилцуулга бэлтгэн хэвлүүлж аймгийн удирдлагууд болон 18 сум 4 тосгон, хэрэглэгчдэд 25 ширхэгийг, цахимаар 25 удаа тархаалаа.</p> | |
| <p>4.1. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах</p> | | |
| <p>4.1.1. Хэрэглэгчдэд</p> | <p>4.1.1. 2017 онд 5 төрлийн сургалт зохион явуулж нийт 847 хүнийг хамруулав.</p> | |

| | | |
|---|--|--|
| <p>зориулсан сургалтыг нутгийн төр, захиргааны байгууллагын ажилтнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд болон иргэдэд зохион байгуулна.</p> <p>4.1.2. Сургалтын тайланг баримтжуулан ҮСХ-нд хүргүүлнэ.</p> | <p>Баг, сумын ажилтнуудад зориулсан сургалт, Аймгийн төвийн 33 албан байгууллагын ажилтнуудад, ерөнхий боловсролын 4 сургуулийн төгсөх ангийн сурагчдад, МСҮТ-ийн төгсөх ангийн сурагчид болон иргэдэд сургалт зохион явууллаа.</p> <p>4.1.2. Өөрсдийн зохион явуулсан сургалтын тайланг тавьсан илтгэлүүдийн хамт тухай бүр ҮСХ-нд хугацаанд нь хүргүүлсэн болно.</p> | |
| <p>5.7. “Хүн ам, өрх”-ийн мэдээллийн сангийн баяжилтыг сумын түвшинд сайжруулан үйл ажиллагаандаа ашиглах;</p> | | |
| <p>5.7.1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сум, багийн түвшинд баяжуулахад хяналт тавин ажиллана.</p> <p>5.7.2. Мэдээллийн сангийн нууцлалыг ханган үйл ажиллагаандаа ашиглах ажлыг өргөжүүлнэ.</p> | <p>5.7.1. ХАӨМС-н ажлын хүрээнд ҮСХ-с ирүүлсэн 3 удаагийн тодруулга, хүн амын үзүүлэлт, өрхийн үзүүлэлтийн алдааг тухай бүрд нь авч ялган 18 сум сум, 88 багт цахимаар хүргүүлэн алдааг засуулах ажил явагдаж байна. Засагдаагүй үлдсэн алдаа нь шилжиж ирсэн болон баталгаажигдаагүй өрх, түр эзгүй гэсэн хувь хүний алдаа үлдсэн байна энэ тухай тайлбарыг нь цаг хугацаанд нь ҮСХ-д хүргүүлэн ажиллалаа. ҮСХ-ны ХАОСТТ-ны Газарзүйн мэдээллийн систем хариуцсан ахлах мэргэжилтэн З.Нямбаяр, хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Наранчимэг нар Хэрлэн сумын 8 багийн зохион байгуулагч нарыг цуглуулан тэдний ХАӨМС-д байгаа алдаа, тэдэнд анхаарч ажиллах талаар мэдээлэл хийж заавар чиглэл өгч ажиллалаа. Энэ ажлын хүрээнд Хэрлэн сумын 5-р баг, 1-р багийн зохион байгуулагч нарт цаашид анхаарч ажиллах талаар сануулга өглөө.</p> <p>ХАӨМС-н ажлын хүрээнд өрхийн байршил тогтоох цэг хатгалтын ажлыг эрчимтэй явуулсны дүнд 100 хувийн гүйцэтгэлээр бүрэн тэмдэглэж дууссан боловч одоогийн байдлаар шинээр шилжиж ирсэн болон баталгаажилт хийгдээгүй өрхүүдээс шалтгаалж өрхийн цэг хатгалт хийгдээгүй байна. Энэ талаар сумдын багийн дарга нарт үүрэг даалгавар өгөн ажиллалаа. Сумдын статистик хариуцсан ажилтан, багийн дарга нар шинээр ажил авч байгаатай холбогдуулан ХАӨМС-н тухай болон ХАӨМС-н программ хангамж, ХАӨМС- дээрх алдааг хэрхэн багийн дарга нараар засуулах талаар сургалтыг 1 удаа хийж 18 сум 4 тосгоны давхардсан тоогоор нийт 106 хүнийг хамруулж сургалттай холбогдож гарсан санал асуулгад дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Сумдын статистик хариуцсан ажилтан болон багийн дарга нарыг шинэ төрсөн хүүхэд болон нас баралт, шилжилт хөдөлгөөн, ХАӨМС-н баяжилтыг тухай бүрд нь хийж гүйцэтгэж байх үүрэг даалгавар өгөн ажиллаж байна. Багийн дарга нар ХАӨМС-д 1213 шинэ төрсөн хүүхэд бүртгэн авч 420 хүний нас баралтыг бүртгэн хасалт хийсэн байна. ХАӨМС-н ажлын хүрээнд 18 сум 88 багийн 10349 алдааг хугацаатай үүрэг өгөн засуулж, байршил тогоогоогүй 761 өрхийн байршлыг тогоолгон, 336 ургийн</p> | |

| | | |
|---|--|--|
| | овгийн алдааг ҮСХ-д өгч зөв ургийн овгоор засуулан алдааг устгуулан ажиллаа. 1.5.2. Багийн дарга болон сумдын статистик хариуцсан ажилтнуудад ХАӨМС-н нууцлалыг ханган үйл ажиллагаандаа ашиглаж, шаардлагатай тоон мэдээллийг ХАӨМС-с гарган авч ажиллах талаар сургалтанд болон өдөр тутмын үйл ажиллагаандаа анхаарч ажиллахыг анхааруулж байнга заавар зөвлөмж өгөн ажиллаж байна. | |
| Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО | | |

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

| <i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i> | <i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i> | <i>Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Манлайллын зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i> |
|---|--|---|
| 1 | 2 | 3 |
| 1. Зорилт 1: Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх; | Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ес зүйн хэм хэмжээг чандлан сахиж ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, байгууллагынхаа ил тод байдлыг ханган ажиллаж байна. Статистикийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг өөрсдийн ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Статистикийн салбарын үйл ажиллагаатай холбоотой УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэр, ҮСХ-ны даргын тушаал шийдвэрийн биелэлтийг тухай бүрт нь хангуулж ажиллалаа. УИХ-с баталсан Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | |
| 2. Зорилт2: Байгууллагын ил тод байдлыг хангах Газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг | Манай хэлтэс энэ жил Үндсэн дансны жилийн батлагдсан төсөв нь 72463.4 мянган төгрөг. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 59448.1 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 6191.6, Бараа үйлчилгээний зардалд 5291.4 мянган төгрөг, Тээврийн хэрэгслийн зардалд 355.5 мянган төгрөгийг зарцуулаад байна. | |

| | | |
|--|--|--|
| <p>ханган ажиллах;</p> | <p>- Нэмэлт санхүүжилтийн данс буюу судалгааны зардлыг нэг бүрчлэн гүйцэтгэлээр нь харахад ӨНЭЗС, АХС-ны зардалд 35671,9 мянган төгрөг, ажилах хүчний туршилтын судалгаанд 959.5 мянган төгрөг, багын засаг дарга нарын сургалтын зардалд 10979,0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого хяналтын зардалд 10744.7 мянган төгрөг, жилийн эцсийн мал тооллого хяналтанд 4500.0 мянган төгрөг, эрчим хүч үйлдвэр үнийн хэрэглээний судалгаанд 1377,0 мянган төгрөг, зөвлөлдөх санал асуулгын судалгаанд 1503,0 мянган төгрөг, бусад төрлийн үнийн мэдээнд 4835,3 мянган төгрөгийг зарцуулаад байна. Тооллого судалгааны анхан шатны санхүүгийн баримтыг тухай бүрд нь бүрдүүлүүлж хянан шалгаж санхүүгийн баримтанд хавсарган ажиллав.</p> <p>- Шилэн дансны цахим хуудсанд тухай бүрт мэдээлэх 8, сар болгон 3, улирал болгон 1, хагас жил 4, бүтэн жилийн 11 мэлээллийг цаг хугацаанд сар болгоны 08-ны дотор иж бүрэн байршуулж ажиллаа.</p> <p>- Хэнтий аймгийн аудитын газар 2017 оны эхны 01-09 сарийн нэмэлт болон үндсэн санхүүгийн тайлан үйл ажилгаанд хяналт хийлээ. Аудитын дүгнэлтээр ямар нэгэн алдаа дутагдал гараагүй.</p> <p>Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны тоологч нар судалгааг хэрхэн зохион байгуулж байгаа байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаанд хамрагдсан өрхүүдэд очиж судалгааны дэвтрийн хөтлөлтийн байдалтай танилцаж, өрхөд олгож буй урамшууллын мөнгө өрхөд олгогдсон эсэхийг баримттай нь тулган шалгах ажлыг сар бүр судалгаанд хамрагдсан бүх суманд хийлээ. ӨНЭЗС судалгаанд хамрагдсан 18 сумын 48 багийн 408 өрхийн 42 өрхөд, АХС судалгаанд хамрагдсан 18 сумын 36 багийн 432 өрхийн 52 өрхөд,</p> <p>Хэлтсээрээ бие дааж хийсэн шалгалт: Аж ахуйн нэгжид- 18, ӨНЭЗС, АХС, судалгааны мониторингоор нийт 94 өрхөд, мал тооллогын хяналт 560 өрхөд тус тус хийсэн байна. Аймгийн бусад байгууллагатай хамтарсан шалгалт 15-ыг хийлээ.</p> | |
| <p>3. Зорилт 3: Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдал, оролцоог хангах, түүнийг зүй зохистой зарцуулах 3.1. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, төрийн болон орон нутгийн өмчийн</p> | <p>- Манай хэлтэс энэ жил 72463.4 мянган төгрөгийн үндсэн төсөвтэй ажиллалаа. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 59448.1 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 6191.6 мянган төгрөг, Бараа үйлчилгээний зардалд 52291.4 мянган төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>- Нэмэлт санхүүжилтийн данс буюу судалгааны зардлыг нэг бүрчлэн гүйцэтгэлээр нь гаргахад ӨНЭЗС, АХС-ны зардалд 36631.4 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 10744.7 мянган төгрөг, жилийн эцсийн мал тооллогонд 4500.0 мянган төгрөг, бусад төрлийн судалгаа болон үнийн мэдээнд 5700.2 мянган төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>- Шилэн дансны цахим хуудсанд тухай бүрт мэдээлэх 8, сар болгон 3, улирал болгон</p> | |

| | | |
|---|--|--|
| <p>хөрөнгөөр бараа үйлчилгээг худалдан авах төсвийн хөрөнгийн зарцуулалтыг нээлттэй болгох.</p> | <p>1, хагас жил 4, бүтэн жилийн 11 мэлээллийг цаг хугацаанд сар болгоны 08-ны дотор иж бүрэн байршуулж ажиллаа.</p> | |
| <p>4.- Зорилт4: Байгууллагын эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах 4.1. Албан хаагчдын ажиллах таатай орчин, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> | <p>1. Эд хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хагас , бүтэн жилээр тоолон бүртгэж шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг Аймаг, ҮСХ-нд гаргаж өгсөн. Хэлтсийн 1 машин хэвийн ямар нэгэн эвдрэл гэмтэлгүй ажиллаж байна. 1 машинаа дуудлага худалдаанд оруулж худалдав. Ажилтнуудад эд хөрөнгийн карт хөтөлж өөрчлөлтийг тухай бүрд нь хийж хэвшлээ.</p> <p>2. Аймгийн ЗДТГ-ын үүдэнд байршуулж байсан цахим самбарыг Эвт худалдааны төвд байрлах Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд шилжүүлэн байршуулж мэдээллийг тогтмол шинэчилж иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа.</p> <p>ҮСХ-оос Видео хурал зарласан тухай бүрд техник хэрэгслэлийг бэлэн байдалд бэлтгэн оролцож, мэдээлэл хүлээн авч байлаа.</p> <p>Хэлтсийн 3 өрөөг өөрсдийн нөөц бололцоогоор тохижуулж цэцэгжүүлж ажиллах нөхцлийг сайжрууллаа.</p> <p>3. ҮСХ-ноос 2 ш үзүүлэлт сайтай компьютер,1 ш принтерээр тусаллаа. Үүнийг хөрөнгөд тусгаж авав.</p> <p>4. Албан хаагчдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэхэд Ассемийн Азийн хөгжлийн хэмжээний чуулганд хандиваар бии болсон албан хэрэгцээнд ашиглаж байгаа хөрөнгөнөөс 19 ширхэг 2536000 мянган төгрөгийн нэр бүхий тавилга эд хогшилоор хангалаа.</p> | |
| <p>5. Зорилт 5: Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх 5.1. Байгууллагын ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх</p> | <p>ҮСХ-ноос болон орон нутагт зохион байгуулагдаж байгаа сургалтанд хэлтсийн дарга, мэргэжилтэн, судлаачид хамрагдаж бүтэн жилийн турш сурсан бүх л Онлайн программ, Таблет, I PAD зэргийг бүрэн эзэмшиж ашиглаж мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Тогтвортой хөгжил статистик үндэсний чуулганд хэлтсээрээ оролцоод ирлээ. - Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр орон нутгийн статистикийн болон хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан боловсруулсан “Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй” сэдэвт сургалтанд 2017 оны 4 дүгээр сарын 13, 14-ны өдрүүдэд, “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөр”-ийн хүрээнд үнэ цуглуулагчдад зориулсан сургалтанд 2017 оны 5 дугаар сарын 23,24-ний өдрүүдэд тус тус мэргэжилтэн Б.Онончимэг оролцсон. - Хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Наранчимэг нь: - ҮСХ-д очиж ЭХҮХ-ний 2015, 2016 оны судалгааны тоологчийн сургалтанд 2 хоног суув. Аймгаас тус судалгаанд ажиллах 2 хүнийг авч сургалтанд суулган ажиллууллаа. - АЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс явуулсан хяналт | |

| | | |
|---|---|--|
| | <p>шинжилгээ үнэлгээний сургалтанд ахлах мэргэжилтэн А.Наранчимэг 1 хоног суулаа.</p> <ul style="list-style-type: none"> - АЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран зохион явуулсан Төрийн албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх сургалтанд ахлах мэргэжилтэн А.Наранчимэг хамрагдан 12 цагийн хичээлд амжилттай сууж батламжлах гэрчилгээ авлаа. - Статистикийн төв орон нутгийн байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх анхан шатны 48 цагийн сургалтанд гэрээт мэргэжилтэн А.Мөнх-Уянга амжилттай суралцаж сертификат, Тод санхүү группын 8 цагын сургалтанд амжилттай хамрагдаж сертификад тус тус гардан авсан. - Хэлтсийн нягтлан бодогч А.Мөнх-Уянга нь Монголын нягтлан бодох бүртгэлийн холбоонд гишүүнээр элсэж нягтлан бодогчийн тангараг өргөв. - ҮСХ-ноос явагддаг онлайн сургалтанд мэргэжилтэн, судлаач нар бүгд идэвхитэй хамрагдаж ирлээ. - Аймаг орон нутагт зохион байгуулагддаг сургалт, хурал зөвлөгөөнд мэргэжилтэн, судлаач нар тухай бүрд нь хамрагдав. | |
| Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО | | |

Хэлтсийн тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Тайлан бичсэн:

Төсвийн шууд захирагч:

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

..... **Т.ӨЛЗИЙСҮРЭН**

(албан тушаал)
(тэмдэг)

(гарын үсэг)

.....
(огноо)

Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

..... **Н.ГАНБЯМБА**

(албан тушаал)
(тэмдэг)

(гарын үсэг)

.....
(огноо)

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

"Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам (цаашид /Журам/ гэх)"-ын 2 дугаар хавсралт "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-ний биелэлтийг дүгнэх)-г үнэлж дүгнэх Үлгэрчилсэн загвар (цаашид /Загвар/ гэх)"-ын дагуу төсвийн шууд захирагчийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнэхэд энэхүү аргачлалыг баримтална.

НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн шууд захирагчийн гэрээний биелэлтийг доорх байдлаар дүгнэнэ:

1.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.1-ийн **нийт арга хэмжээ (гарц)** тус бүрийн хэрэгжилтийг Загварын хавсралт маягт (*Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан*)-аар гаргах бөгөөд арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр уг маягтын харгалзах 3 дахь баганад нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд **0-30** онооны үнэлгээ өгч, **дундаж оноог** гаргана.

Хэрэв тухайн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн саналын дагуу төсвийн шууд захирагч нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэхээр тохирсон бол түүний биелэлтийг нэгэн адил үнэлнэ.

Тухайн арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн бол 30, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үр дүнд бүрэн хүрээгүй бол 20-29, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаж, ажил хийгдэж байгаа бол энэ ажлын түвшинг харгалзан 14-19, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 5-13, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж эхэлсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 1-4 оноо өгч, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил хийгдээгүй бол оноо ("0" гэж тэмдэглэнэ) өгөхгүй.

Нийт арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний дундаж оноог тооцохдоо арга хэмжээ тус бүрт өгсөн онооны нийлбэрийг үнэлгээ өгсөн арга хэмжээний нийт тоонд хувааж гаргана.

Загварын 1.1-ийн **"нийт арга хэмжээ (гарц)-ний"** гэсний өмнөх зайд гэрээгээр хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээнээс бусад нийт арга хэмжээний тоог бичиж, Загварын Хүснэгт 1-ийг дараах байдлаар бөглөнө:

Жишээ:

| Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо | Өгвөл зохих оноо | Өгсөн оноо (дундаж оноо) |
|--|-------------------------|---------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 20 | 0-30 | 25 |

1.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.2-ын **тусгай арга хэмжээ** тус бүрийн хэрэгжилтийг Загварын 1.1-ийн нийт арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн аргачлалаар дүгнэнэ.Загварын хавсралт маягт (*Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан*)-ын харгалзах 3 дахь баганад тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд **0-40** онооны үнэлгээ өгч, **дундаж оноог** гаргана. Тухайн арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн бол 40, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үр дүнд бүрэн хүрээгүй бол 29-39, тухайн арга хэмжээг

хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаж, ажил хийгдэж байгаа бол энэ ажлын түвшинг харгалзан 18-28, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 7-17, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж эхэлсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 1-6 оноо өгч, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил хийгдээгүй бол оноо ("0" гэж тэмдэглэнэ) өгөхгүй.

Тусгай арга хэмжээний хэрэгжилтийн дундаж оноог тооцохдоо тусгай арга хэмжээ тус бүрт өгсөн онооны нийлбэрийг үнэлгээ өгсөн тусгай арга хэмжээний нийт тоонд хувааж гаргана.

Загварын 1.2-ын **"тусгай арга хэмжээ (гарц)-ний"** гэсний өмнөх зайд гэрээгээр хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний нийт тоог бичиж, Загварын Хүснэгт 2-ыг дараах байдлаар бөглөнө:

Жишээ:

| Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо | Өгвөл зохих оноо | Өгсөн оноо (дундаж оноо) |
|---|-------------------------|---------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 5 | 0-40 | 35 |

1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.3-ын манлайллын зорилт тус бүрийн хэрэгжилтийг Загварын хавсралт маягтын дагуу зорилт бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан зорилт бүрийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр уг маягтын харгалзах 3 дахь баганад зорилт бүрийн биелэлтэд **0-30** онооны үнэлгээ өгч, **дундаж оноог** гаргана.

Манлайллын зорилтын биелэлтийн үнэлгээний дундаж оноог тооцохдоо зорилт тус бүрт өгсөн онооны нийлбэрийг үнэлгээ өгсөн нийт зорилтын тоонд хувааж гаргана.

Загварын 1.3-ын **"зорилт (орц)"** гэсний өмнөх зайд гэрээгээр хэрэгжүүлбэл зохих манлайллын зорилтын нийт тоог бичиж, Загварын Хүснэгт 3-ыг дараах байдлаар бөглөнө:

Жишээ:

| Манлайллын зорилт (орц)-ын тоо | Өгвөл зохих оноо | Өгсөн оноо (дундаж оноо) |
|---------------------------------------|-------------------------|---------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 6 | 0-30 | 20 |

1.4.Төсвийн шууд захирагчийн **мэдлэг чадвар** нь нийт болон тусгай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, манлайллын зорилтыг хангахад тусгалаа олох тул түүнийг тусгайлан дүгнэхгүй боловч биелэлтийг Загварын 1.4-ийн **"биелэлт:"** гэсний дараах зайд бичнэ.

1.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь **төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллахтай** холбогдсон төсвийн шууд захирагчийн хүлээсэн үүргийн биелэлтэд **дүгнэлт** өгч, Загварын 1.5-ын **"дүгнэлт:"** гэсний дараах зайд бичнэ.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэхдээ:

2.1.Гэрээнд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээсэн үүргийн биелэлтийг зүйл тус бүрээр талууд хамтран хэлэлцэнэ.

2.2.Талууд төсвийн ерөнхийлөн захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг **дүгнэж**, Загварын 2-ын “**биелэлт:**” гэсний дараах зайд бичнэ.

2.3.Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээгээр хүлээсэн зарим үүргээ биелүүлээгүйгээс төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд сөргөөр нөлөөлсөн гэж талууд үзвэл төсвийн шууд захирагчийн тухайн хүлээсэн үүргийн биелэлтэд өгөх үнэлгээнд энэ нөхцөл байдлыг харгалзана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.1, 1.2, 1.3-т өгсөн үнэлгээг нэгтгэн Загварын Хүснэгт 4-ийг дараах байдлаар бөглөж, нийт оноог гаргана:

| <i>Гэрээний үзүүлэлт</i> | <i>Өгвөл зохих оноо</i> | <i>Өгсөн оноо (дундаж онооны жишээ)</i> |
|--|-------------------------|---|
| 1 | 2 | 3 |
| 1.Нийт арга хэмжээ (гарц)-ний хэрэгжилт | 0-30 | 25 |
| 2.Тусгай арга хэмжээ (гарц)-ний хэрэгжилт | 0-40 | 35 |
| 3. Манлайллын зорилт (орц)-ын биелэлт | 0-30 | 20 |
| Нийт оноо | 0-100 | 80 |

3.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээний **нийт оноог** үндэслэн гэрээний биелэлтэд журмын 6.4.1-6.4.5-д заасан үнэлгээний аль нэгийг өгнө.

3.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээний **нийт оноо** (бидний авсан жишээгээр **80** оноо)-г үндэслэн гэрээний биелэлтэд (бидний авсан жишээгээр “**В**” буюу “**Сайн**” гэсэн) үнэлгээ өгөх бөгөөд Загварын Хүснэгт 5-ын зохих баганад (бидний авсан жишээгээр “**В**” баганад) үнэлгээгээ эж тэмдэглэнэ.

3.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэв “**А**” буюу “**Маш сайн**”, эсхүл “**Д**” буюу “**Дутагдалтай**”, “**Ф**” буюу “**Хангалтгүй**” гэсэн үнэлгээний аль нэгийг өгсөн бол энэ тухай үндэслэлээ Загварын 3.2-ын холбогдох зайд бичнэ.

4. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төсвийн ерөнхийлөн захирагч нь гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн журмын 7.1-д заасан үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ (урамшуулах, эсхүл хариуцлага хүлээлгэх)-ний тодорхой саналаа Загварын 4-т бичнэ.

5. Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт

Загварын 5.1-д үнэлгээ өгсөн төсвийн ерөнхийлөн захирагч, 5.2-т үнэлгээтэй танилцсан төсвийн шууд захирагч тус тусын гарын үсгийг зурж, эрх бүхий этгээд тэмдэг дарж албажуулна.

..... о о о